

“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024.04.29

№ ХТ-24/01

Улаанбаатар хот

Огноо: **2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр**

Цаг: **10:00-12:00**

Хурал болсон газар: **“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн хурлын танхим**

Хурлын дарга: **Даваадорж Балжинням /ТУЗ-ийн ердийн гишүүн/**

Хурлын нарын бичгийн дарга: **Д.Цэцгээ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/**

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: **26**

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: **86,300,419**

Хурлын ирц: **86.7%**

Хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай,
2. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсөв батлах тухай,

“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 10:00 цагт “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн хурлын танхимд явагдлаа. Хуралд хурлын дарга Д.Балжинням, ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл, ердийн гишүүн Д.Дэлгэрмаа, Б.Батцэцэг, хараат бус гишүүн Б.Ганбаатар, Ч.Амарбаатар, Д.Балдорж, Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн болон компанийн удирдлагын багийн гишүүд болон аймгийн ШҮГ-ын дарга нар биечлэн оролцлоо.

Хурлын бүртгэлийг 10:00 цагт хааж, тооллогын комиссын дарга О.Сарангэрэл хурлын ирцийн мэдээллийг хурлын даргад мэдээлснээр хурал эхэллээ.

Хурлын дарга Д.Балжинням: Сайн байцгаана уу. Та бүхэндээ энэ сайхан өглөөний мэндийг дэвшүүлье. “Монгол шуудан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж байна. Хурлын дэгийг ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 24/04 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан.

- Хурлын дарга Д.Балжинням хурлын дэгийг танилцууллаа.

Хурлын дарга Д.Балжинням: Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан танилцуулна уу хэмээн гүйцэтгэх захирал Г.Тэлмэнг урьж байна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1: Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: “Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн дарга, гишүүд болон өнөөдөр хувьцаа эзэмшигчдийн хуралдаа оролцож байгаа хувьцаа эзэмшигчиддээ энэ өдрийн мэнд хүргэе. Тайлан танилцуулахаас өмнө нийт хувьцаа эзэмшигчиддээ өөрийгөө танилцуулъя. 2024 оны 04 дүгээр сарын 01-нд ТУЗ-ийн шийдвэрээр “Монгол шуудан” ХК-ийн гүйцэтгэх захирлаар томилогдсон. Миний хувьд компанийг нээлттэй хувьцаат компани болсноос нь хойш ээлжит болон ээлжит бус 10 дах хувьцаа эзэмшигчдийн хуралдаа оролцож байна. 2016-2020 онд “Монгол шуудан” ХК-ийн стратеги, бизнес төлөвлөлтийг хариуцсан дэд захирлаар ажиллаж байсан. 2020-2024 оны 3 сар хүртэл ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллаж байгаад компанийн гүйцэтгэх захирал чөлөөлөгдсөнтэй холбогдолтойгоор нээлттэй сонгон шалгаруулалтаар өөрийн хүсэлтийг өгч, шалгарч орж ирсэн. Компанийн 2023 оны тайлан танилцуулахын хамт

компанийн 2024 оны 1-р улирлын үзүүлэлтийг танилцуулаад, цаашид бид юу хийхээр төлөвлөж байгаа талаараа товчхон мэдээлэл өгье. Ажлаа аваад 4 долоо хоног болж байна. Энэ хугацаанд нөхцөл байдал, үйл ажиллагаатайгаа танилцах, цаашид богино хугацаанд сайжруулж, хэрэгжүүлж болох арга хэмжээнүүдийг авах, урт болон дунд хугацаанд төлөвлөх зүйлсийг хийгээд явж байна.

- Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн компанийн 2023 оны тайлан болон компанийн өнөөгийн байдлыг танилцууллаа.

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: Ажил аваад компанийн өнөөгийн нөхцөл байдал ямар байна вэ гэдэг дээр дүгнэлт хийж байна. Хэд хэдэн тулгамдсан асуудлууд байна. 1-рт хүний нөөцийн тогтвор сууршлын асуудал хүндрэлтэй байдалд байна. Ажлаас гаралтын коэффициент 44 хувьтай, ажилд оролтын коэффициент 57 хувьтай, тогтвортой байдлын коэффициент 72 хувь руу бууж анхаарал хандуулах байдал руу бууж байна. Гол асуудал нь юундаа байна вэ гээд үзвэл ажилтнуудын цалин Улсын дундаж цалингаас 900 мян.төг-өөр бага, салбарын дундаж цалингаас 200 мян.төг-өөр бага байна. Орон нутгийн дундаж цалин Улсын болон салбарын дунджаас бага байна. 4 дүгээр сарын 01-ээс Төрийн байгууллагуудын ажилтнуудын цалинг орон нутагт мэдэгдэхүйц хэмжээгээр өсгөчихсөн байгаа. Энэ нь зах зээл жижигтэй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд хүндээр тусаж байна. Иймээс бид яаралтай орлогоо нэмэгдүүлэх, ажилтнуудда тохирсон цалин урамшуулал авах бололцоогоор нь хангаж, үйл ажиллагаагаа явуулахгүй бол болохгүй. Шуудан компанийн хувьд нийт үйл ажиллагааны 70 хувь нь цалингийн зардал байдаг. Мөн гараас гарт, биетээр хүргэдэг үйлчилгээ учраас тогтвортой боловсон хүчинтэй, шуудангийн технологи нь стандартын дагуу явах нь маш чухал байдаг. Орон нутгийн алдагдал 2023 онд 1.3 тэрбум төгрөг гарсан байгаа. Компани дотоодын шуудангийн үйлчилгээний дийлэнх хувийг үзүүлдэг хэдий ч стандартын агуулах терминал, зориулалтын тоног төхөөрөмж байхгүй, гар ажиллагаагаар 50-60 кг-ын ачааг зөөж буулгах, ачих, хүргэх ажлыг хийж байна. Иймээс зориулалтын агуулах, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэргээр хүргэлтийн чанарыг сайжруулах наад захын стандарт хангасан тоног төхөөрөмж үйлчилгээндээ нэвтрүүлэх нь зайлшгүй шаардлагатай харагдаж байна. Аудитлагдаагүй санхүүгийн тайлан 3 сарын 31-ний байдлаар танилцуулахад нийт үйл ажиллагааны ашиг 26.2 сая төгрөгийн алдагдалтай, валютын ханшийн зөрүүний олз өнгөрсөн жилд транзит шуудан зогссонтой холбоотойгоор алдагдалтай болж ирсэн. Эндээс тайлант үеийн цэвэр алдагдал 555.0 сая төгрөг болж байна. Компанийн 2023 оны сүүлд баталсан төсвөөс зөрүүтэй явж байна. Бизнесийн хувьд 20 хувиас илүү хэлбэлзэж байгаа бол оны төгсгөлд барьж авахад хэцүү гэж үздэг. Яаралтай арга хэмжээ авч, тодотгол оруулах, богино хугацаанд буюу үлдсэн 3 улиралд яаралтай орлого төвлөрүүлэх ажлыг хийх зайлшгүй шаардлагатай байна.

Хурлын дарга Д.Балжинням: Г.Тэлмэн захиралдаа баярлалаа. Танилцуулгууд яваад эхэлсэн учраас хуралд оролцож байгаа ТУЗ-ийн гишүүд болон удирдлагыг багыг танилцуулъя гэж бодлоо. Б.Анхбаатар захирал хувийн шалтгааны улмаас өөрийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдөөд, компани нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, 7 нэр дэвшигч материалууд ирүүлснээс хамгийн өндөр оноо авч Г.Тэлмэн гүйцэтгэх захирлаар томилогдсон.

- Хурлын дарга Д.Балжинням хуралд оролцож буй ТУЗ-ийн дарга, гишүүд болон удирдлагын багийн бүрэлдэхүүнийг танилцууллаа.

Хурлын дарга Д.Балжинням: ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Д.Балдорж компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт, хараат бус гишүүн Б.Ганбаатар ногдол ашгийн тайлан танилцуулна.

- ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Д.Балдорж компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн аудитын хорооны дүгнэлтийг танилцууллаа.
- ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Ганбаатар компанийн 2022 оны ногдол ашиг тараасан тухай тайлан, 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцууллаа.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Сайн байцаана уу. Хувьцаа эзэмшигчиддээ энэ өдрийн мэнд хүргэе. 2 агуулгаар тайлан танилцуулна. ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагаа болон компанийн 2023 оны ажилд ТУЗ нь ямар дүгнэлт өгч байгаа талаар танилцуулна.

- ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл ТУЗ-ийн 2023 оны тайлан дүгнэлтийг танилцууллаа.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг ТУЗ хэлэлцээд дүнгээ тавьсан. Транзит шуудангийн үйлчилгээ 10 дугаар сараас эхлээд зогссонтой холбоотойгоор орлогын хэмжээ буурах зэргээр асуудлууд үүссэн. Үндсэн үйл ажиллагаа дээр алдагдалтай ажилласныг та бүхэн мэдэж байгаа. Мөн үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор өрсөлдөгч нар бий болж байгаа зэргээр олон шалтгаанууд байна. Орон нутгийн салбарууд бүгд алдагдалтай ажиллаж байна. Улаанбаатар хотод болон транзит шуудангийн орлогоор орон нутгийн зардлыг давж гараад ашигтай ажиллана гэдэг нь компанийн хувьд сорилт болсон. Компанийн хувьд Дэлхийн шуудан холбооны байгууллагын гишүүн байгууллагын хувьд ямар ч алдагдалтай байсан шуудангаа хүргэх Засгийн газрын үүргийг өөр дээрээ үүрч явдаг учраас бүх нийтийн үүргийг хүлээж байгаа компанийн хувьд хүндрэлтэй. Орон нутагт ажиллаж байгаа ажиллагсдын цалингийн систем дээр томоохон өөрчлөлтийг 2023 онд хийсэн. Сумын шууданчдын цалинг хийснээр нь цалинжуулах, орсон орлогоос нь хамааруулан нэмэгдэл цалин олгодог систем рүү шилжсэн. Транзит шуудангийн үйлчилгээний орлогоос гадна хүргэлтийн үйлчилгээ дээр Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Цахим Монгол” үндэсний хөтөлбөртэй нийцүүлээд И-Монголиа, “Хурдан” систем гээд нэлээд олон үйлчилгээг үзүүлж байгаа. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хэлж буйгаар “Хурдан” системээр хийгдэж байгаа ажлыг төлбөртэй болгох, Засгийн газраас тодорхой хэмжээгээр санхүүжүүлэх ажлыг цаашид хийнэ гэсэн амлалтыг өгсөн. Компани 2023 оны үр ашгийн төлөвлөгөөг тодорхой хэмжээнд биелүүлсэн, өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ажшигласан гэж үзэж ТУЗ-өөс компанийг “Сайн” ажилласан гэсэн дүнг өгсөн. Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Хурлын дарга Д.Балжинням: Д.Нарангэрэл даргад баярлалаа. Хурлын дэгийн дагуу асуулт, хариултын цаг эхэлж байна. Танилцуулгуудтай холбоотой асуух асуулт, санал байвал гараа өргөөд, өөрийгөө танилцуулаад асуултаа асууна уу.

Хувьцаа эзэмшигч Б.Сайнжаргалын итгэмжлэгдсэн төлөөлөгч: Би хувиараа бизнес эрхлэгч Ч.Даваадолгор гэж хүн байна. Өнгөрсөн онуудад ажил үүргээ амжилттай гүйцэтгэж ирсэн “Монгол шуудан” ХК-ийн хамт олонд баярлаж талархсанаа илэрхийлье. Би хувьцаа эзэмшихээс гадна компанийн үйлчлүүлэгч. Компанийн гараас гарт хүргэлтийн үйлчилгээ аваад бараг 3 жил болж байна. Эхлээд хувь хүнээр үйлчлүүлж байсан. Одоо харилцагч компани болсон. Энэ өнгөрсөн 3 жилийн хугацаанд нэг удаагийн асуудлыг үл тооцвол найдвартай үйлчилгээ үзүүлж ирсэн. “Монгол шуудан” ХК-д хүргэлтээ өгөөд явуулчихвал сэтгэл амар байдаг. Бусад хувийн компаниудаар ийм итгэлтэй үйлчлүүлж чаддаггүй. Өнгөрсөн хугацаанд үйлчлүүлж байсан учраас нөхцөл байдлыг мэддэг тул хэд хэдэн санал хэлье гэж бодлоо. 1-рт хүргэлтийн хувьд зах зээл хангалттай байгаа гэж бодож байна. Гэрээт компаниудаас гадна хувь хүний хүргэлтийн ажил явахаа байсан харагдсан. Энэ тал дээр барьж буй бодлого юу вэ. Ковид-оос хойш, цахим худалдааны хүргэлт, соёл улам өсөлттэй боллоо. 2-рт орон нутгийн хүмүүс бидэнтэй адилхан цаг алдалгүй мэдээллийг аваад явж чаддаг боллоо. Гэтэл орон нутгийн хүргэлт нь шуудангаар явахаар 7-10 хонодог удаан байна. Иймээс заавал мөнгө гаргаж машин авна гэхээсээ илүүтэйгээр хуваарилалтыг нь өөрчлөх гэх мэтээр орон нутгийнхаа хүргэлтийг хурдлуулах арга хэмжээ авч өгнө үү. 3-рт хүргэлтийн ажилтнууд ойр ойрхон солигддог. Үүнээс болж энэ хүн Монгол шуудангийн ажилтан мөн үү гэдгийг мэдэхэд хэцүү болдог. Хүргэлтийн 2 хуудас цаас байдаг. Би тэр баримтаар нь л таньдаг. Иймээс ажилтнуудаа энгэрийн зүүлт ч юм уу ямар нэг байдлаар хялбар таньж болох нийтлэг дүр төрхтэй болгох хэрэгтэй харагдсан. Энэ нь нэгдүгээрт компанийн нүүр царай, хоёрдугаарт үйлчилүүлэгчид компанид итгэх найдвартай байдал болно.

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: Ч.Даваадолгор харилцагчийн асуултад хариуулъя. Дэд захирал Н.Хосбаяр нэмж тайлбар хэлээрэй. Гараас гарт хүргэлтийн үйлчилгээ бол бидний зах зээл дээр гаргаж ирсэн үйлчилгээ. Ковидын үед нэлээдгүй сайшаалыг хүртсэн. Орлогоо нэмэгдүүлэхээр

байгууллагуудтай уулзахад асуудалгүй, хүргэлтийн зах зээл хангалттай байна. Гэвч бид хүргэлтээ чанартай хийж чадаж байна уу гэдэг дээр дүгнэлт хийх ёстой цаг болоод байна. Дотоодын хүргэлтийн хувьд эхний 72 цагт 48 хувийн хүргэлт хийгдэж байна. Үүссэн шалтгаанууд нь юу вэ гээд хараад үзэхээр таны хэлдэгтэй шууд холбогдоно. Ажилтнуудын оролт, гаралт их байна, хүргэгч нарын хувцас хэрэгсэл гээд олон асуудал байна. 4 сард ирээд хүргэлтийн чанарыг сайжруулах шаардлагатай бүх худалдан авалтыг яаралтай зохион байгуулж байна. Хүргэлтийн чанарыг яаралтай шийдэхгүй бол юун зах зээл тэлэх вэ гэдэг асуудал яригдсан. Удахгүй ТУЗ-ийн хурлаар төлөвлөгөөгөө тодотголоор оруулж байж хүргэлтийн чанар, чадавхийг сайжруулах ажлуудыг хийх шаардлагатай байна. Нөгөө талдаа орлогоо өсгөөд явах хангалттай зах зээл байгааг харж байгаа. Хүргэлтээ хийж чадахгүйтэй холбоотойгоор системээ зогсоосон асуудал хүртэл байгаа. Орон нутгийн асуудал хүнд байгаа. Энэ нь орон нутгийн хүргэлтийн солилцоо бага байгаатай холбоотой, тэр бүр өдөр болгон өөрийн тээвэр явуулах боломж байдаггүй. Иймээс автотээврийн төвүүдээс зорчигч тээврийн автобусаар гэрээгээр хүргүүлдэг. Энэ нь төдийлөн чанартай хүргэлт хийж чадахгүй байна гэдэг дүгнэлтэд хүрсэн явж байна. Автотээврийн үндэсний төвийн даргатай ярьсан. Монгол шуудан компанийн шууданг нэн тэргүүнд авдаг байх зохицуулалтыг хийж өгөхөөр тохирсон. Хүргэлтийн ажилтнуудыг ойр ойрхон солигддоггүй байх, тогвор сууршилтай ажиллуулдаг байх талаар хүний нөөцийн эрс өөрчлөлт хийж, цалин урамшууллын системийг нь хүртэл өөрчлөх шаардлага гарч байгаа. Одоогоор яаралтай 3 ажлын хэсэг гаргасан. Эдгээр нь хүргэлтийн чанарыг дээшлүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа, хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуй, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангасан худалдан авалт болон хөрөнгө оруулалтуудыг шийдүүлэх, богино хугацаанд орлого төвлөрүүлэх, бүтцийн оновчлол, цалин урамшууллын системийг зөв зохистой болгох, их ачаалалтай байгаа гүйцэтгэлээрээ илүү авдаг байх, жигд хуваариалалтыг хийх гэх мэт чиглэлээр ажиллаж байна. Яг салбар дээр газар дээр нь очиж үзэхээр ажилтнуудын тогтвор сууршилтай ажиллах нь багассан хэдхэн олон жил ажилласан хүмүүс дээр нь ачаалал нь ихэдсэн нөхцөл байдалтай байна. Гашуун ч гэсэн бодит үнэнтэйгээ тулж ажиллах хэрэгтэй байна. Энэ жилдээ сайжруулалтуудыг хийнэ гэсэн итгэл байгаа учраас нэр дэвшиж орж ирж ажиллаж байна. Ажлууд хийгдэж эхэлж байгаа шүү гэдгээ хэлье.

Дэд захирал Н.Хосбаяр: Сайн байцгаана уу. Гараас гарт үйлчилгээний хувьд таны хэлсэнчлэн гэрээт байгууллагууд дээрээ үйлчилгээгээ үзүүлээд явж байгаа. Хүн хүчний байдал, техникийн хүчин чадалтай холбоотойгоор гэрээ байгуулсан байгууллагуудынхаа үйлчилгээг чанартай хүргэх тал дээр анхаарч байгаа учраас хувь хүмүүсийн захиалгыг өнгөрсөн 2 сараас хойш хаагаад явж байгаа. Энэ үйлчилгээг ойрын хугацаанд нээхээр төлөвлөгөө гаргаад ажиллаж байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд 2 ажлыг зайлшгүй хийх шаардлага гарсан. Програм хангамжийн хувьд системээ шинэчлэх, хүн хүчний дутагдал буюу оролт гаралтыг тогтворжуулах гэсэн 2 ажлыг хийгээд явж байна.

Хурлын дарга Д.Балжинням: Их чухал асуудлыг хөндөж санал тавьсан хувьцаа эзэмшигч танд баярлалаа. ТУЗ-ийн гишүүн болон хувь хүнийхээ хувьд нэг зүйл хэлье гэж бодлоо. Таны хэлсэн асуудал өнгөрсөн оноос хойш ТУЗ-ийн хурал дээр яригдсан. Компани бизнесийн загвараа эргэж харах шаардлагатай байна. Бидний захиа, цаасан хэлбэрийн шуудан зөөдөг үе өнгөрлөө. Зах зээл өөр болж байна. Иймээс компани алсын хараагаа тодорхойлоод дунд, урт хугацааны бодлого, бизнесийн загвараа эргэж харъя, цахим худалдаа логиستيкийн чиглэл рүү орох хэрэгтэй байна. Өрсөлдөгч компаниуд зах зээл дээр олон гарлаа гэх мэтээр ТУЗ-ийн зүгээс компанийн удирдлагуудтай ярьсан. Бид энэ жилдээ багтаагаад энэ бүгдийг тодорхой болгоод шийдэл гаргая гэж ярьж байна. Бид компаниас шаардана, ярилцана, шийдэл гарцаа гаргаад явах байх.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Амарбаатар: Миний асуух гэж байсан асуултын үндсийг Д.Балжинням гишүүн маш тодорхой хэлчихлээ. ТУЗ-ийн даргаас асуух асуулт байна. Төрийн өмчийн компаниудын шийдвэр гаргадаг процесс удаан юм байна. Би өмнө нь төрийн өмчтэй компанид ажиллаж байгаагүй учраас их удаан санагдсан. Монгол шуудан компани төрийн үйлчилгээ үзүүлэхээс гадна хүргэлтийн компани шүү гэдгээ зөвшөөрөх хэрэгтэй. Мэдээлэл цахимаар явах нь ойлгомжтой болсон учраас бид амьд байх утга учир нь хүргэлт. Монгол шуудан компани хүргэлтийн номер нэг компани болохын төлөө ажлаа тодорхой болгочих

хэрэгтэй байна. Энэ бүх ажлыг энэ жилдээ багтаж гэж хойшлуулалгүй алсын хараагаа тодорхойлоод, Төрийн өмч болон Засгийн газартай ярилцаад шийдвэрийг нь гаргаж өгөхгүй бол ирэх жил ашиг хувааж чадахгүйд хүрэх гээд байна.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Бид урт, богино хугацааны стратеги төлөвлөгөөг ярьж байгаа. Энэ ажил өнөөдрийг хүртэл батлагдаагүй байгаа нь төрийн өмчтэй ямар ч холбоогүй. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ТУЗ хуралдах үед нь төрийг төлөөлж байгаа гишүүдэд удирдамж, чиглэл өгдөг. Компанийн зүгээс стратеги бодлогын бичиг баримтаа гаргаад ирвэл ТУЗ -ийн дэргэдэх хороодоор хэлэлцэж, дүгнэлт гаргаж байгаад шийдээд явчихаж болно. Энд цаг хугацаа ороод удаашраад байх зүйл байхгүй. Иймээс Г.Тэлмэн захирал судалж байгаад үндсэн чиглэлд өөрчлөлт оруулах уу, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах уу, шаардлагатай тохиолдол гарвал бид хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах ч боломжтой. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулах шаардлагагүй бол ТУЗ-өөрөө бид бүх асуудлыг шийдээд явах боломжтой. Бид цаг хугацаандаа хуралдаад шийдвэрээ гаргаад явдаг. Шинэ захирал компанийг стратеги бодлогын хувьд өөрчлөө, зах зээлтэйгээ нийцүүлбэ, өөр байдлаар ажиллая гэсэн байдлаар судалгаа, бодлого, төлөвлөгөө ойрын хугацаанд гаргаж ирэх байх гэсэн хүлээлттэй байгаа. ТУЗ-ийн зүгээс гүйцэтгэх захирлын оруулж ирсэн бодлого, төлөвлөгөөг хэлэлцээд компанийг хөгжүүлэхийн төлөө бүх зүйлийг хийж ажиллах болно.

Хурлын дарга Д.Балжинням: ТУЗ-ийн хараат бус гишүүн болон ТУЗ-ийн даргадаа баярлалаа.

Төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч В.Дарханбаатар: Сайн байцгаана уу. Миний хувьд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ирсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага төлөөллийн албаны дарга В.Дарханбаатар гэж хүн байна. ТУЗ-ийн хараат бус гишүүний асуулт болон гүйцэтгэх захирлын танилцуулсан тайлан, танилцуулгатай холбоотойгоор хэд хэдэн зүйл хэлбэ. "Монгол шуудан" ХК-ийн хувьцаа эзэмшигчид, ТУЗ, гүйцэтгэх удирдлага нэлээд хурдтай ажиллахгүй бол зах зээлээсээ хоцроод байгаа юм байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Засгийн газар "Монгол шуудан" ХК-ийн үйл ажиллагааг нэг секунд, нэг минутаар хойшлуулах тухай ямар ч ойлголт байхгүй. Аль болох ирж байгаа, гарч байгаа саналыг хэр бодитой, үндлэслэлтэй, хуульд нийцүүлсэн байна гэдэг дээр нь мэргэжлийн хувьд үзэж, танилцаад удирдамжаа цаг тухай бүрд нь богино хугацаанд гаргаж өгөөд явж байгаа. Цаашид бид "Монгол шуудан" ХК-ийг сайн засаглалтай компани болгохын тулд тодорхой зүйлүүдийг хийх шаардлагатай байна. Нэг үйлчилгээ доголдоод ирэхэд алдагдал руу ороод ирдэг асуудал гаргамааргүй байна. Гүйцэтгэх захирал танилцуулгадаа хэд хэдэн ажил төлөвлөөд хийх гэж байгаагаа хэлсэн. Иймээс тэр ажлуудаа аль болох хурдан хийж эхлээрэй. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зүгээс дэмжиж ажиллана. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд орон нутгийн удирдлагууд сууж байгаа нь талархалтай байна. Та бүхний бас нэг хийх ёстой зүйл бол сумдын шуудангийн төлөөллүүдийн барилга байшин, тоног төхөөрөмжүүдээс эхлээд анхаарах зүйлүүд маш их байгаа. Энэ тал дээр тодорхой төлөвлөгөө гаргаад ажиллах байх гэдэгт гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-д итгэж байна. Та бүхний цаашдын ажилд амжилт хүсье.

Хурлын дарга Д.Балжинням: В.Дарханбаатар даргад баярлалаа. Өөр асуулт, санал байна уу.

Өөр санал, хүсэлт байхгүй гэснээр дараагийн хэлэлцэх асуудал руу орлоо.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 2: "Монгол шуудан" ХК-ийн дүрэмд орох нэмэлт өөрчлөлтийг батлах тухай

Хурлын дарга Д.Балжинням: Компанийн дүрэмд орох нэмэлт өөрчлөлтийг компанийн хуулийн зөвлөх О.Отгонбаяр танилцуулна.

Компанийн хуулийн зөвлөх О.Отгонбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. "Монгол шуудан" ХК нь 1921 оноос хойш хэд хэдэн төрлөөр статус нь өөрчлөгдсөн. Хамгийн сүүлд 2016 онд нээлттэй хувьцаат компани болж өөрчлөн зохион байгуулагдсан. Компанийн дүрэм 2016 онд батлагдсанаас хойш өөрчлөлт ороогүй байгаа. Анхны төрийн өмчийн нээлттэй хувьцаат

компани гэдэг утгаараа, 2016 оноос хойш гарсан хууль тогтоомжийн өөрчлөлттэй холбоотойгоор дүрэмд өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага гарсан.

- Компанийн хуулийн зөвлөх (Худалдан авах ажиллагааны албаны дарга) О.Отгонбаяр компанийн дүрэмд орох нэмэлт өөрчлөлтийг дэлгэрэнгүй танилцууллаа.

Хурлын дарга Д.Балжинням: Хуулийн зөвлөх О.Отгонбаярт баярлалаа. Дүрмийн өөрчлөлттэй холбоотойгоор асуулт байна уу.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Амарбаатар: Автомашинаар ачаа тээвэрлэх гэдэг нь ямар утгаар орсон бэ. Ид зуны цагт мопедоор зөөвөл бас дүрэмдээ өөрчлөлт оруулах уу.

Компанийн хуулийн зөвлөх О.Отгонбаяр: Шуудан хүргэлттэй холбоотой ерөнхий зохицуулалт нь шуудангийн үйлчилгээ үзүүлэх үндсэн үйл ажиллагаатай холбоотой учраас энэ нь хүргэлтийн хүрээнд болчихно. Авто машинаар ачаа тээвэрлэх гэдэг нь ямар учраас оруулж ирж байна вэ гэхээр Авто тээврийн тухай хууль болон Автотээврийн үндэсний төвөөс тавьж байгаа олон улсын тээврийн "С" зөвшөөрөл авахад шаардлагатай зохицуулалт байгаа.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Ганбаатар: Аудитын, Цалин урамшууллын болон Нэр дэвшүүлэх хороодын дарга нь ТУЗ-ийн дарга бус хараат бус гишүүн байна гэж бусад ТУЗ-ийн гишүүдийн эрхийг хязгаарласан харагдаж байна.

Компанийн хуулийн зөвлөх О.Отгонбаяр: Санхүүгийн зохицуулах хорооноос тавьж байгаа шаардлагын дагуу боловсруулагдсан. Санхүүгийн зохицуулах хорооноос компанийн засаглалын кодексийг шинэчлэн батлаад, үүнийг хувьцаат компаниуд заавал биелүүлэх шаардлагатай байгаа. Энд хараат бус гишүүд хороодын даргаар ажиллах нь илүү зохимжтой байна. Компанийн засаглалын хувьд олон улсын шаардлагад нийцэж байна гэж харж байгаа.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: ТУЗ-ийн хурал дээр КТХ-ийн хүрээнд нийцүүлээд энд хараат бус гишүүн байж болно гэсэн найруулгаар оруулья гэж яригдсан. Хуулийн зохицуулалт нэг яваад, хуулиа барьж болох, дүрмээ ч барьж болох зохицуулалт яваад байгаа. Хуулиар бол Аудитын хорооны дарга хараат бус гишүүн байна гэж заасан байдаг. Бусад хороод дээр дүрмээр хориг заалт тавихгүйгээр байж болно.

Компанийн хуулийн зөвлөх О.Отгонбаяр: Найруулгын хувьд өөрчлөлт оруулья. Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүл, эсвэл тайлбарла гэсэн шаардлага тавьж байгаа.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Редакцийн засвар байна. 2.2 дээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан зорилтот түвшин биш, стратеги төлөвлөгөөнд үндэслэн гэж оруулья. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас бид компанийн стратегийг баталдаг. Үүндээ үндэслээд бодлогын төлөвлөгөөг жил бүр батлаад явдаг. Иймээс зорилтот түвшин гэдгийг стратеги төлөвлөгөө гэсэн найруулгын өөрчлөлт оруулья.

Хурлын дарга Д.Балжинням: Өөр асуулт байхгүй бол найруулгын өөрчлөлтүүдийг оруулаад дүрмээ баталъя.

Өөр санал хүсэлт байхгүй гэснээр дараагийн хэлэлцэх асуудал руу орлоо.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 3: ТУЗ-ийн 2024 оны зардлын төсөв батлах тухай;

Хурлын дарга Д.Балжинням: ТУЗ-ийн 2024 оны зардлын төсвийг хараат бус гишүүн Ч.Амарбаатар танилцуулна.

- ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Амарбаатар ТУЗ-ийн 2024 оын зардлын тасвийг танилцууллаа.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Амарбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. ТУЗ нь 2023 оны шатахуун, томилолтын зардлаа хэмнэж ажилласан. 2024 онд томилолтын зардлыг нэмэх тал дээр ТУЗ зөвшөөрч шийдвэр гаргаж өгсөнд баяртай байна. Энэ жилийн хувьд дотоодын зах зээл гэхээсээ илүүтэйгээр гадаад зах зээл рүү түлхүү оролцье гэсэн санал тавьсан. Саяхан Эрээн хотод дэд захиралтай хамт уулзалт зохион байгуулж, амжилттай ажилласан. Үг хэлэх нь миний зорилго байгаагүй. Би энд алдагдал хүлээнэ гэдгийн мэдэж хувьцаа эзэмшиж орж ирсэн. Миний хувьд 10 гаран жил эдийн засгийн коридор гэж ярьж байгаа. Энэ эдийн засгийн коридор гэдэг нь Монгол Улсын Засгийн газрын хөтөлбөрт ороод ирсэн байгаа. Яагаад хүргэлтийн компани юм бэ гэдэг зүйлийг тодорхой болгох ёстой. Бидэнтэй хамтарч ажиллаж байсан SF компани бол 70 гаруй ачааны Военг онгоцтой, 700 мянгаад ажилтантай компани. Ийм нүсэр том бүтцийг бий болгож болж байна. Иймээс бид олон улсын нэр дээр гараад ирсэн энэ том нэрийг зөв ашиглаад энэ бүх ажлыг хийж болох юм байна гэдэг үндэслэлээр Монгол шууданг сонирхож орж ирсэн. Орон нутгийн алдагдлын хувьд хэрэв бид Засгийн газрын үүргийг хүлээж байгаа бол энэ зардлыг Засгийн газар хариуцах ёстой гэсэн байр суурьтай байна. Улс хоорондын шуудан ялган боловсруулах төвийг нээж байх үед Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл дарга хувь, төрийн хэвшлийн түншиллийн сайн үлгэр жишээ гэж хэлж байсан. Иймээс энэ компанийг хөгжүүлэх ёстой юм байна гэсэн итгэл үнэмшил байгаа. Оны сүүлээс зөрчлүүд их гарсан. Бид энэ зөрчлийг ойлголцож, гаргалгааг нь сайн гаргаж ажилласан. Хөгжлийн төлөвлөгөөгөө сайн гаргаж, зөв тодорхойлоод, үр дүнгээс хамаарч ажилладаг систем рүү орж ажиллаж байж ажил хийх сонирхолтой болгох ёстой. Анхаарал тавьсанд баярлалаа.

Хурлын дарга Д.Балжинням: Ч.Амарбаатар гишүүнд баярлалаа. Танилцуулгатай холбоотойгоор асуулт байхгүй бол түр завсарлага авъя. Энэ хооронд тооллогын комисс хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналын хуудсыг нэгтгэж дүнг танилцуулна.

Завсарлага 11:35-11:55 цагийн хооронд боллоо. Тооллогын комисс саналын хуудсын дүнг нэгтгэж дууссан тул хурлыг эхлүүллээ.

Хурлын дарга Д.Балжинням: Дараагийн үйл ажиллагаанд оръё. Тооллогын комисс саналын хуудсыг нэгтгээд дууссан гэсэн мэдээ өгч байна.

- Тооллогын комиссын дарга О.Сарангэрэл санал хураалтын дүн буюу тооллогын комиссын тогтоолыг танилцууллаа.

Хурлын дарга Д.Балжинням: Тооллогын комиссын даргад баярлалаа. Хурлаас гарах шийдвэрийн төслийг танилцуулъя.

- Хурлын дарга Д.Балжинням Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрүүдийг танилцууллаа.

Хурлын дарга Д.Балжинням: Хурлаас гарах шийдвэрийн төслийг танилцууллаа. 100 хувийн саналаар батлагдсан. Өнөөдрийн хурал үүгээр өндөрлөж байна. Хуралдаа идэвхитэй оролцсон та бүхэнд баярлалаа. Цаашдын ажил үйлсэд нь амжилт, хамгийн сайн сайхныг хүсэн ерөөе.

Энэ удаагийн хурал 12:00 цагт өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА:

Д.БАЛЖИННЯМ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Д.ЦЭЦГЭЭ

